

**МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДАА,
ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ
ШИНЖ ЧАНАРУУД (1990-2020 он)**

А.ДАВААСҮРЭН

Доктор (Sc.D), профессор

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн

Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа

судлалын салбарын эрхлэгч,

1990 оноос эхлэн хоёр улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос чөлөөт зах зээлийн зарчим руу, нэг нам давамгайлсан авторитари буюу захиргаадгалтын улс төрийн тогтолцооноос ардчилсан нийгэм рүү шилжих шилжилтийг эхэлүүлсэн. Энэ нь Монгол Улс, ОХУ-ын харилцааг зах зээлийн шинэ нөхцөлд шинэ агуулга, хэлбэр, шинэ зарчимд тулгуурлан хөгжүүлэх шаардлага гарсан. Энэхүү хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд 1993 оны 1 дүгээр сарын 19-22-нд Монгол Улсын анхны ерөнхийлөгч П.Очирбатын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг” байгуулсан нь зах зээлийн нөхцөлд хоёр орны харилцаанд зарчмын цоо шинэ үндэс болсон юм.

Дараа нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2000 оны 11 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн анхны албан ёсны айлчлалын үеэр тэрээр: “Монгол-Оросын сайн хөршийн харилцааг харилцан туслах хамтран ажиллах олон жилийн бат зузаан уламжлалын үндсэн дээр сэргээн хөгжүүлэх шийдвэр төгс байгааг илэрхийлэн “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд Монгол Улс онцгой байр эзэлдэг”¹ гээд Айлчлалын үеэр талууд “Улаанбаатарын тунхаглал”-д хоёр тал гарын үсэг зурсан нь шинэ зуунд Монгол, Оросын харилцааг шинэ шатанд гаргаж, бүх талаар хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, харилцан ашигтай хамтын ажиллагааны улс төрийн үндэс суурийг тавьсан юм.

Иймд 1990-2020 онд зах зээлийн нөхцөлд Монгол Улс, ОХУ-ын харилцаа нь худалдаа, эдийн засгийн гэхээс илүү улс төр, геополитикийн шинж чанартай болж байна. Хэдийгээр хоёр орны худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд Монгол Улсын экспортын бараа, бүтээгдэхүүнд ОХУ-ын талаас тавьж байгаа гаалийн тарифын бус хориг ба тарифын зохицуулалт ихээхэн бэрхшээл саад учруулж байна гэж үзэх талтай ч гэсэн хамгийн гол нь хуучин социализмын үед Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнуудын хооронд бий болсон эдийн засаг,

¹ Выступление перед депутатами Великого государственного хурала Монголии./ <http://kremlin.ru/events/president/transcripts/21133>

аж үйлдвэр, технологи, ажиллах хүч, бараа, түүхий эдийн хангамж, нийлүүлэлт, үйлдвэрлэл, худалдааны интеграцийн холбоос тасарсан нь үндсэн шалтгаан болсон гэсэн дүгнэлтийг хийх нь зохистой болов уу. Үүнтэй холбоотой манай улсын уул уурхай, мал аж ахуйн түүхий эдийг импортоор авч ашигладаг байсан ОХУ-ын боловсруулах үйлдвэрүүд устаж үгүй болсон тул хоёр улс аль аль нь хохирол амссан гэж үзэж болно.

Нөгөө талаас ОХУ, Казахстан, Белорус, Армян, Кыргызстаны ЕвроАзийн эдийн засгийн холбооны (хуучин Гаалийн холбоо) зүгээс нэн тааламжтай нөхцөл болон хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгодог хөгжиж буй орнуудын жагсаалтад Монгол Улсыг багтааж манай улсын экспортын бараа, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамааруулан гаалийн өндөр татвар ногдуулж байгаа нь манай хоёр орны худалдааны эргэлтийг багасгахад нөлөөлсөн гэж үзэх талтай. Өмнө хэлсэн хүчин зүйлсийн үр дүнд 2020 оны байдлаар Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд ОХУ 11,3 хувь, экспортод 0,8 хувь, импортод 26,4 хувийг тус тус эзэлж, жил тутам буурсаар байна.

Хүснэгт 1. Монгол Улс, ОХУ-ын худалдааны эргэлтийн хэмжээ, сая доллар

Он	Нийт эргэлт	Экспорт	Импорт	Тэнцэл ба алдагдал
2005	445,2	27,2	417,9	-390,7
2006	592,9	45,1	547,8	-502,7
2007	803,5	58,5	745,0	-686,5
2008	1328,6	86,3	1242,3	-1156,0
2009	841,0	68,2	772,8	-704,6
2010	1129,4	82,7	1046,7	-964,0
2011	1721,0	96,3	1624,7	-1528,4
2012	1927,0	79,6	1847,4	-1767,8
2013	1623,6	61,8	1561,9	-1500,1
2014	1610,9	61,6	1549,3	-1487,7
2015	1097,9	76,9	1021,0	-944,1
2016	936,2	55,8	880,4	-824,6
2017	1284,9	67,7	1217,3	-1149,6
2018	1796,3	85,9	1710,3	-1624,4
2019	1798,0	68,1	1729,9	-1661,8
2020	1457,2	57,3	1400,0	-1342,7

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн хорооны жил тутмын статистикийн эмхэтгэл, 2005-2020 он.

Хүснэгт 1-ээс харахад хоёр улсын худалдааны эргэлтийн үнийн дүнгийн динамик тогтвортой бус, хэлбэлзэлтэй байхад манай улсын экспортын үнийн дүн буурах, ОХУ-аас авч байгаа импортын хэмжээ өсөх хандлагатай байна. Энэ

нь дэлхийн зах зээл дээрхи бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ тарифын хэлбэлзлэлээс шалгаалсан манай улсын дотоод зах зээл дээрхи эрэлтийн чиг хандлагаас хамаарч байгаа дүр зураг ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улс нь тодорхой нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн болон газрын тосны бүтээгдэхүүний импортын хувьд ОХУ-ын зах зээлээс хараат байгааг илтгэж байна.

Монгол, Орос улсын эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээг илтгэх өөр нэг чухал үзүүлэлт бол хоёр улсын хөрөнгө оруулалт юм. 1990 оноос хойш Монгол Улсын эдийн засагт нийт 23669,7 сая долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсон байна. Үүнээс 1990-2004 оны хооронд 1120,9 сая доллар буюу 4,7 хувь нь, 2005-2019 оны хооронд 26582,8 доллар буюу 95,2 хувь нь орсон байна. Тэгвэл 1990-2019 онд Монгол улс руу ОХУ-аас 397,2 сая долларын шууд хөрөнгө оруулалт орсон байна.

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засагт ОХУ-аас орсон шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, сая доллар

Он	МУ-ын нийт хөрөнгө оруулалтын хэмжээ	ОХУ-аас орсон хөрөнгө оруулалтын нийт хэмжээ	Нийт дүнд эзлэх хувь, %
1990-2004	1120,9	37,2	3,3
2005	316,8	7,5	2,4
2006	366,5	11,7	3,2
2007	499,9	39,8	8,0
2008	708,9	3,8	0,5
2009	801,1	6,1	0,8
2010	1025,9	2,3	0,2
2011	4986,0	58,0	1,2
2012	3198,7	129,6	4,1
2013	1219,0	2,1	0,2
2014	1988,2	2,8	0,1
2015	1394,6	9,8	0,7
2016	1458,4	4,2	0,3
2017	1996,1	30,2	1,5
2018	2644,1	18,0	0,7
2019	2857,7	34,2	1,2
Нийт	26582,8	397,2	100,0

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний хөгжлийн газрын Гадаадын хөрөнгө оруулалтын газрын статистикийн мэдээлэл 2019 он.

Хүснэгт 2-оос харахад дэлхийн эдийн засгийн хямралын дараа дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ огцом өссөнөөс шалтгаалан 2010-2013 онд Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэний дагуу Монгол Улсын эдийн засаг руу орсон ОХУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн боловч нийт хөрөнгө оруулалтад эзлэх тус улсын хувийн жин маш чамлалтай 0,5-1 хувийг эзлэж байгаа нь хоёр улс хөрөнгө оруулалтын салбар дахь хамтын ажиллагаа тааруу гэж үзэхээр байна. Үүн дээр хоёр улсын найрамдал, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны бэлэг тэмдэг болсон уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн ОХУ-ын талд ногдож байсан 49 хувийн хувьцааг 2016 онд Монголын талд худалдсан нь хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны үзүүлэлт өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Үүнд улс төр, геополитикийн гэхээс илүү эдийн засгийн хүчин зүйл нөлөөлсөн байх гэж үзэж байна. Ингэснээр хоёр улсын хувь нийлүүлсэн хувьцаат нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-аас өөр ОХУ-ын хөрөнгө манай улсад үгүй болсон.

Хүснэгт 3. Монгол Улсын ГШХО-тай компаний тоонд ОХУ-ын шууд өрөнгө оруулалтай компаний эзлэх хувийн жин, хувиар

Он	Монгол Улсын ГХО-тай компаний тоо	ОХУ-ын хөрөнгө оруулалтай компаний тоо	Нийт дүнд эзлэх хувь, %
1990-2004	3696	433	11,72
2005	971	54	5,56
2006	1506	105	6,97
2007	1611	72	4,47
2008	1551	51	3,29
2009	614	37	6,03
2010	791	20	2,53
2011	964	35	3,63
2012	796	22	2,76
2013	381	14	3,67
2014	336	10	2,98
2015	298	10	3,36
2016	284	10	3,52
2017	407	10	2,46
2018	486	13	2,67
2019	233	6	2,58
Нийт	14925	902	6,04

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний хөгжлийн газрын Гадаадын хөрөнгө оруулалтын газрын статистикийн мэдээлэл, 2019 он.

1990-2019 онд Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай нийт 14925 компаний бүртгэгдсэн байна. Үүнд ОХУ-ын хөрөнгө оруулалттай 878 компани буюу манай улсын нийт гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаний 6,2 хувийг эзлэж байна.

2005-2019 онд манай улсад бүртгэгдсэн нийт компаний 6,04 хувийг ОХУ-ын компаний эзлэж байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 12 жилийн байдлаар ОХУ-ын хөрөнгө оруулалттай компаний тоо буурч байна.

Эндээс дүгнэж хэлэхэд Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын дотор ОХУ-ын хөрөнгө оруулалттай компаниудын тоо тогтмол буурах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл ОХУ-аас манай улсад хөрөнгө оруулж бизнес эрхлэх хүмүүсийн сонирхол буурч байна гэж үзэхээр байна.

Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүндрэлтэй байдлаас гарах гол хүчин зүйл бол ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутгаар дайруулан барих байгалийн хийн хоолой гэж үзэж байна.

Зураг 1. ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутгаар дайруулан барих байгалийн хийн хоолойн бүдүүвч.

ПРЕДПОЛАГАЕМЫЙ МАРШРУТ НОВОГО ГАЗОПРОВОДА В КИТАЙ

ИСТОЧНИК: «ГАЗПРОМ».



Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр шийдсэн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хийн хоолой барих техник, эдийн засгийн үндэслэлийг ОХУ-ын “Газпром” нээлттэй хувьцаат нийгэмлэгийн “Газпровод союз восток” тусгай зориулалттай компани боловруулж, 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

хоёр тал баталсан байдаг. Энэхүү хоолой нь хүчин чадал урьдчилсан байдлаар 1 жилд 50 тэрбум м³ байгалийн хий дамжуулах бөгөөд тус улсын хүн ам хамгийн их төвлөрсөн нийслэл Улаанбаатар хот болон Дархан, Сүхбаатар, Зүүнхараа, Зуунмод, Чойр, Сайншанд, Замын-Үүд зэрэг хот суурин газрыг дайран төмөр замын үндсэн шугамын дагуу томоохон гол мөрөн гатлах эсвэл ёроолоор нь татахгүй, уул нуруу, далан шуудуу сэтлэхгүй маш богино хугацаанд их хэмжээгээр хямд зардлаар баригдахаар байна. Одоо уг хоолойн техникийн зураг төслийг хийх үлдээд байгаа бөгөөд ойрын үед дуусгахаар төлөвлөж байна.

Хэрэв уг хоолойноос салаалж улмаар хүн ам төвлөрсөн Улаанбаатар хотод байгалийн хийг ахуйн болон үйлдвэрлэлд ашиглах тал дээр ОХУ-тай тохиролцож чадвал манай улсын эдийн засагт хий түгээх, хангах цоо шинэ дэд салбар бий болж цахилгаан, дулааны үнэ, тариф буурах нөхцөл бүрэлдэж газар тариалан, мал аж ахуй эрчимжих боломжтой бөгөөд, эдийн засгийн бусад салбаруудын (зам тээвэр, логистик, хими, технологи, хар ба өнгөт төмөрлөг) хөгжилд дэвшил гарч нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бөгөөд үйлдвэрлэл үйлчилгээний үнэ, тарифын хэмжээ буурч улмаар ДНБ-ий хэмжээ ойролцоогоо 20 орчим хувиар нэмэгдэнэ гэж үзэж байна.

Дүгнэж хэлэхэд шинэ 2022 оны босгон дээр Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд байгалийн хийн хоолой гэсэн цоо шинэ хэлбэр бий болж байна. Монгол Улсын төсөвт орох ёстой хийн хоолойны транзит татварын орлого нь манай улсын төрийн санхүүгийн чадавхийг сайжруулах, төсвөөр дамжуулан санхүүжих улс орны дунд, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдэд заасан мега төслүүдийг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэр бий болох, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, улмаар банкны зээлийн хүүг бууруулах, ингэснээр шинээр олон тооны ажлын байр бий болгох, ард иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, ядуурлын түвшинг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байна.

Ашигласан ном зүй:

1. А.Даваасүрэн, “Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд гарсан өөрчлөлт” / судалгааны ажлын тайлан, Улаанбаатар, 2018 оны 5 сар, 8,31 х.х.
2. Монгол Улсын засгийн газрын тохируулагч агентлаг, Үндэсний хөгжлийн газрын Гадаадын хөрөнгө оруулалтын газрын гадаадын хөрөнгө оруулалтын тоон мэдээлэл 2019 он.
3. Дэлхийн банкны судалгаа. (2017). Гадаадын шууд хөрөнгө оруулалтын стратеги. <http://data.worldbank.org>.
4. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны Статистикийн жил тутамын эмхэтгэл 2000-2020 он., www.nso.mn,
5. Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын Гаалийн статистик мэдээллийн систем, 2020, <http://www.customs.gov.mn/statistics/>

6. Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын цахим мэдээллийн хуудас, <http://customs.gov.mn/>
7. Выступление перед депутатами Великого государственного хурала Монголии./ <http://kremlin.ru/events/president/transcripts/21133>
8. Ангела Меркел: “Nord Stream 2” хоолойг улс төрийн зэвсэг болгон ашиглавал ОХУ-д эдийн засгийн хориг тогтооно. 2021 оны 8 сарын 23, <http://itoim.mn/>
9. <https://gas.in-en.com/html/gas-3553508.shtml>
10. КазМунайГаз ба CNPC 2009 онд MangistauMunaiGaz-ийг 3,3 тэрбум ам.доллараар худалдан авсны үр дүнд Mangistau нефтийн орд тэдний мэдэлд орж ирсэн., <https://ria.ru/20210928/gaz-1752110760.html>
11. Скрылев С. А. Тюменские проекты Большого Уренгоя // Энергетическая стратегия : журнал. — 2012. — №2 (20). — С. 13.
12. ОАО «Газпром»: Ачимовские залежи. Дата обращения: 18 июля 2012. Архивировано 29 июня 2012 года.
13. “Европарламент предложил усилить санкции против России” <https://lenta.ru/news/2014/04/17/sanction/>
14. Владимир Путин: Россия в нынешних условиях не может продолжать реализацию «Южного потока», от 1 декабря 2014, <https://russian.rt.com/article/62268>
15. Мордюшенко О. и другое. Клуб друзей «Газпрома» построит «Турецкий поток» в Европе // Коммерсантъ : газета. — 08.04.2015. — № 61. — С. 1.
16. «Газпром» сделал трубный выбор, Коммерсантъ (22 ноября 2018).
17. Сайт ОАО “Газпром”, www.gazprom.ru
18. Эксперт: «Северный поток» демонстрирует эффективное сотрудничество России с европейскими странами, от 03 октября 2011г. <https://er.ru/activity/news/ekspert-severnyj-potok-demonstriruet-effektivnoe-sotrudnichestvo-rossii-s-evropejskimi-stranami>
19. 20 Largest Natural Gas Fields in the World, <https://www.worldlistmania.com/20-largest-natural-gas-fields-in-the-world/>
20. <https://www.worldlistmania.com/20-largest-natural-gas-fields-in-the-world/>
21. ОПЕС Annual Statistical Bulletin 2020 (англ.). Дата обращения: 9 декабря 2020.